# ДОЛОО. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

## 7.1. 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлт

Байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай үйл ажиллагаа явуулж, нөхөн сэргээлтийн ажлыг стандартын дагуу хугацаанд нь гүйцэтгэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг 2020 онд хийгдсэн БОНБНҮ-ний зөвлөмжийн дагуу бүрэн хэрэгжүүлэн ажиллаж байна.

### 7.1.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Уурхайн үйл ажиллагааны явцад учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгахад дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн ажиллав.

Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө нь Уурхайн дотоод үйл ажилгааны зардалд тусгагдаж явагддаг тул тухайн хэсэг албадуудад ажлын төлөвлөгөө, чиглэлийн дагуу хийж гүйцэтгэсэн болно. Үүнд:

- ▶ Агаарын тоосжилт бохирдлыг бууруулахын тулд зам усалгааны 40 тн-ы даацтай TEREX автомашин /2ш/ болон БНХАУ-ын “Dongfeng” үйлдвэрийн 20 тн-ы даацтай усны машинуудаар уурхайн зам талбай, мод, бут, сөөг услаж байгаа.
- ▶ “Хог хаягдал цуглуулах, хадаглах, тээвэрлэх, устгах журам”-ын дагуу Ахуйн болон аваарын эмнэлэгийн хогийг зайлуулах болон устгах ГЭРЭЭГ батлуулан хэрэгжүүлж ажилласан.
- ▶ Хөрс, газрын гадаргын хувьд төлөвлөгөөний дагуу уурхайн хэсэг нэгжүүд, мөн ШТС-ын ажилтнуудаар тус тус орчны цэвэрлэгээ хийлгүүлж, үүрэг даалгавар өгч ажилласан.
- ▶ Гүний болон гадаргын усны түвшингийн хэмжилтийн бүртгэл, мөн шахсан усны хэмжээг баталгаажуулалт хийгдсэн тоолуураар хянаж, бүртгэх ажлуудыг төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн.
- ▶ ХАБЭА-н хэлтэстэй сөрөг нөлөөллийг бууруулахаар дараах ажлуудыг хамтран гүйцэтгэсэн.

**Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээ** **Хүснэгт №1**

| Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх ажил | Тайлбар | Төсөв мян.төг | Хариуцах эзэн | Аргачлал, стандарт | Ажлын биелэлт |
|---|---|---|---|---|---|
| Уурхайн тоосжилт ихтэй орчинд Шивээ-говь сумын БОМ-ий хяналттай мониторингийн цэг тогтоон агаарын тоосны сорьц авч тодорхойлуулах. | Говьсүмбэр аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв лабораториар агаарын бохирдлын шинжилгээг 5, 9-р сард 15 цэгт хийлгэсэн. Үүний дагуу МХГ-аар дүгнэлт гаргуулан Уурхайн ХАБЭА-н хэлтэстэй хамтран Ажилчидын аюулгүй ажиллагааг хангаж ажиллаж байна. | 900.0 | ТехБХ<br>БОМ<br>ХАБЭА | MNS 4585:2007 | 100 % |
| Зам талбай услах | TEREX машинаар хоногт 12 рейс, DONGFENG машинаар хоногт 8 рейс усалгаа хийв. | 24 295.68 | АБХ | 2020 оны БОНБНҮ тайлан | 100 % |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Түлшээр ажилладаг тоног төхөөрөмжүүдээс ялгарах утааны хэмжээг хянаж, яндангийн оч баригч зэргийг тогтмол шалгаж, эвдэрсэн эд ангийг шинэчилж байх. | Уурхайд байрлах бүх талбай хамрагдана. Тээврийн хэрэгслээс үүсэх хорт хийн ялгарлыг бууруулан ажилласан. | ҮА-ын зардалд | АБХ, УНХ, ТҮХ-ийн ерөнхий механикууд график гарган эвдрэл засварыг хариуцах. | Агаарын тухай хууль MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4601:2011 Автотээврийн хэрэгслийн техникийн үйлчилгээ засварын тогтолцоо тодорхойлол | 100% |
| Тэмдэгжүүлэлт хийх, сайжруулах. | Олон салаа зам гаргахаас сэргийлж, тоосжилт нэмэгдэхээс сэргийлэв. | 1 800.0 | Замын инженер, ХАБЭА | MNS 4595:2007 | 100% |
| Байнгын ажиллагаатай зам, талбай, зогсоолын хучилтыг сайжруулах, арчлах. | Замын инженер, АБХ-ийн мастерууд төлөвлөгөө гарган ажилласан. | ҮА-ын зардалд | Замын инженер | | 100% |
| Нүүрсний өөрөө шаталтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах. | Ээлжийн инженер өдөр бүр хяналт тавьж ажилласан. | ҮА-ын зардалд | Ээлжийн инженер | Агаарын чанар Техникийн ерөнхий шаардлага. MNS 4585:2016 | 100% |
| Ахуйн хог хаягдлыг хогийн цэгт байршуулан богино хугацаанд зайлуулж, бохирын худагт тогтсон хугацаанд ариутгал хийх. | Уурхайн орчинд 2 хогийн цэг байгуулан графикийн дагуу хогоо ачиж зайлуулсан. Мөн ландфилийн аргаар хогоо булшилхаар төлөвлөж хийв. | ҮА-ын зардалд | ХАБЭА, БОМ | Хогны тухай хууль | 100% |
| **Нийт хувь /%/** | | **25 298.38** | | | **100.0%** |

**Хөрсөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ Хүснэгт №2**

| Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх ажил | Тайлбар | Төсөв мян.төг | Хариуцах эзэн | Аргачлал, стандарт | Ажлын биелэлт |
|---|---|---|---|---|---|
| Эвдрэлд орсон газрын хөрсийг нөхөн сэргээх. | Хөрсний үржил шим сайжируулахаар график гарган ажилласан. | ҮА-ын зардалд | 4-р сараас 10-р сард. УНХ, АБХ, Байгаль орчны мэргэжилтэн | MNS 5917:2008 MNS 5914:2008 MNS 5915:2008 MNS 5916:2008 | 100 % |
| Олон салаа зам гарган хөрс эвдэхээс урьдчилан сэргийлэх | Компанийн дотоод журмын дагуу замын инженер олон салаа зам үүсгэхээс сэргийлж сар бүр төлөвлөгөө гарган ажилласан. | ҮА-ын зардалд | ТехБХ Замын инженер | | 100 % |
| Шатах, тослох материалын хадгалалтад хяналт тавих, орчныг тусгай хучилттай болгох. | Хөрсний бохирдлоос хамгаална. | ҮА-ын зардалд | 5-р сараас 8-р сард. АБХ, ЗасХ, ТҮХ, ШТС-ийн эрхлэгч | MNS 5916:2008 | 100 % |
| Шимт хөрсийг хуулах | Биологийн нөхөн сэргээлт хийх талбайд буулган шимт хөрсжүүлсэн. | 3 645.0 | УНХ | MNS 5917:2008 | 100 % |
| Хөрсний хяналт шинжилгээ хийлгэх | Говьсүмбэр аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв лабораториар хөрсний шинжилгээг 5, 9-р сард 9 цэгт хийлгэсэн. Үүний дагуу МХГ-аар дүгнэлт гаргуулан Уурхайн ХАБЭА-н хэлтэстэй хамтран аюулгүй ажиллагааг хангаж ажиллаж байна. ШТС болон АБХ, ЗХ-ийн саармагжуулан хусаж цэвэрлэв. | 800.0 | ТехБХ БОМ ХАБЭА АБХ ЗХ, УНХ | MNS 5850:2008 | 100 % |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Уурхайн ашиглалтын талбайн үржил шимт хөрсийг овоолго үүсгэн хадгалах, өгөршилд орохоос сэргийлэх | Уурхайн ашиглалтын талбайн үржил шимт хөрсийг гадаад овоолгын ар талд стандартын дагуу байршуулсан. | 91 520.0 | ТехБХ, БОМ, УНХ | MNS 5917:2008 | 100% |
| Нөхөн дүүргэх, овоолго хийх | Хоосон орон зайг 4 290.6 мян.$м^3$ шороо дүүргэсэн. | 3 651 300.6 | УНХ | MNS 5917:2008 | 100 % |
| Техникийн нөхөн сэргээлт | 4.5 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг хийсэн. | ҮА-ын зардалд | УНХ | MNS 5918:2008 | 100 % |
| **Нийт хувь /%/** | | 3 747 265.6 | | | **100%** |

**Гадаргын болон газрын доорхи усанд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээ**

**Хүснэгт №3**

| **Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх ажил** | **Тайлбар** | **Төсөв мян.төг** | **Хариуцах эзэн** | **Аргачлал, стандарт** | **Ажлын биелэлт** |
|---|---|---|---|---|---|
| Талбайн АБХ, ЗХ орчимд хатуу ба шингэн хог хаягдал, нефтийн бүтээгдэхүүн хаяхгүй байж, гадаргын уст цэгийн орчныг цэвэрлэх. | Улиралд нэг удаа “Хаялага нуур”-ын орчмын талбайн хог цэвэрлэгээ хийж, усны бохирдлоос хамгаална. | ҮА-ын зардалд | Байгаль орчны мэргэжилтэн, АБХ, ЗХ, УНХ, ШТС | Ариун цэврийн тухай хууль MNS 5775:2007 MNS 900: 2005 MNS 6148:2010 MNS 4943:2008 | 100 % |
| Гүний худгийн усны шүүрүүлэлтэнд хяналт тавих | 7 хоног бүр хяналт хийсэн. | ҮА-ын зардалд | УШХ | MNS 4943:2000 | 100 % |
| Харьяа байгууллагатай ус ашиглах гэрээ байгуулж ус ашигласны төлбөр төлөх. | Ус ашиглах дүгнэлт гэрээний дагуу төлбөр төлөгдөөд явагдаж байгаа. | | Ерөнхий инженер, Ерөнхий ня-бо, Гидрогеологич инженер | Усны тухай хууль | 100 % |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Усны шинжилгээг орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт заасны дагуу Шивээ-говь сумын БОМ-ий хяналттай хийлгэх. | Говьсүмбэр аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв лабораториар усны шинжилгээг 7 цэгт, микробиологийн 3 цэгт шинжилгээ хийгдсэн. Үүний дагуу МХГ-аар дүгнэлт гаргуулан Уурхайн ХАБЭА-н хэлтэстэй хамтран аюулгүй ажиллагааг хангаж ажиллаж байна. | 1 500.0 | ТехБХ БОМ | | 100% |
| Уурхайн ойролцоо хяналтын цооногт газрын доорхи усны төвшингийн өөрчлөлтөнд хяналт тавих. | Сар бүрийн 30, 31-нд хяналтын цооногт төвшинг хэмжиж Усны сав газар болон Шивээ говь сумын байгаль хамгаалагчаар баталгаажуулсан. | ҮА-ын зардалд | Гидрогеолог ич инженер, УШХ | Усны тухай хууль | 100% |
| Уурхайн ашиглалтын талбайг үерийн уснаас хамгаалан далан шуудуу татах. | Дулааны улиралд хийж гүйцэтгэсэн. | ҮА-ын зардалд | УНХ АБХ | Усны тухай хууль | 100% |
| **Нийт хувь /%/** | | 1 500.0 | | | **100 %** |

**Ургамалд үзүүлэх нөлөөллийг багасгах арга хэмжээ** **Хүснэгт №4**

| **Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх ажил** | **Тайлбар** | **Төсөв мян.төг** | **Хариуцах эзэн** | **Аргачлал, стандарт** | **Ажлын биелэлт** |
|---|---|---|---|---|---|
| Ургамлын мониторинг хийх | Нөхөн сэргээлтийн талбай болон Уурхайн бүсэд байрлах ургамалыг БОНБНҮ хийлгэсэн мэргэжилийн байгууллагын зөвлөмжийн дагуу мөрдөн хувийг тооцоолно. | ҮА-ын зардалд | ТехБХ БОМ | MNS 5918:2008 | 100 % |
| Биологийн нөхөн сэргээлтийн ажлыг технологийн дагуу гүйцэтгэх | Төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 4.5 га талбайд биологийн нөхөн сэргээлтийг хийсэн. | 5 600.0 | ТехБХ БОМ | MNS 5918:2008 | 100 % |
| **Нийт хувь /%/** | | | | | **100%** |

**Агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний талаар авч хэрэгжүүлэн шинжилгээ хийлгэсэн зураг**



**Зураг № 1** Вагон ачилтын бункерын зааланд



**Зураг № 2** Вагон ачилтын орчинд



**Зураг № 3** Уурын зуухны орчинд




**Зураг № 4** ЭШ 25/90 Алхагч экскаваторын дотор зааланд

**ОХШХ-ийн дагуу Агаарын тоосжилт хэмжиж байгаа байдал**



**Зураг № 5** Хатаахын зүүн болон хойд талын замын усалгаа



**Зураг № 6** Уурхайн 2-р амын зам усалгаа



**Зураг № 7** ТДХ-ийн агуулах орчимын хөрсний дээж



**Зураг № 8** Уурхайн гадаад овоолгын хөрсний дээж

**ОХШХ-ийн дагуу Хөрсний дээж авч байгаа байдал**



**Зураг № 9** Хаялага нуур луу ус цутгах хоолой



**Зураг № 10** Уурхайн Цайны газрын цэвэршүүлсэн ус

**ОХШХ-ийн дагуу ажлын байрнууд болон хаялага нуурын хоолойноос усны шинжилгээ хийсэн.**

## 7.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт

"Шивээ Овоо" ХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 7-р сарын тогтоолоор батлагдсан Байгаль орчны журмын 4.9-ийн 4.9.8, 4.9.9-д заасны дагуу компанийн тухай хуулийн 83-р зүйлийн 83.1, Хөдөлмөрийн дотоод журмын 3-р зүйлийн 3.1 дэх заалт, Захирлын зөвлөлийн 2018 оны 8-р сарын 22-ны өдрийн хурлын шийдвэрээр А/82-ийн 1-р хавсралт, А/83-ийн 5-р хавсралт тушаалаар батлагдсан "Уурхайн нөхөн сэргээлтийн аргачилал", "Шимт хөрстэй ажиллах заавар"-ын дагуу хийгдсэн болно.

2022 онд нөхөн сэргээлтийн ажлыг дор дурьдсан үндсэн чиглэлээр MNS 5915-2008, MNS 5916-2008, MNS 5917-2008, MNS 5918-2008 стандартуудын дагуу гүйцэтгэж ажилласан.

### 7.2.1 Техникийн нөхөн сэргээлт

2022 оны техникийн нөхөн сэргээлтийн ажлыг дараах чиглэлүүдээр уулын ажлын төлөвлөгөөнд тусган, компанийн бизнес төлөвлөгөөнд зардлыг суулгаж хийхээр төлөвлөж ажилласан болно.

**Нөхөн дүүргэлт: Тээвэргүй**

IX-XIII шугамын хооронд 2045.8 мян.$м^3$ хөрс хуулж, 2244.8 мян.$м^3$ дахин шидэлт, 996.7 мян.$м^3$ инженерийн ажлыг ЭШ-25/90, ЭШ-11/70 алхагч экскаваторуудаар тус тус гүйцэтгэсэн байна.

**Тээвэртэй хөрс хуулалт:**

Үндсэн хөрс 3938.7 мян.$м^3$, нүүрсний давхарга үеүдийн хоорондох завсрын хөрс 1133.5 мян.$м^3$, тус тус хуулахаар ажилласан.

**Шимт хөрсийг хуулах:** Уулын ажлын төлөвлөгөөний дагуу шимт хөрс 46.1 мян.$м^3$ шимт хөрсийг 0.20 м-ийн зузаантайгаар хуулж биологийн нөхөн сэргээлт хийх талбайд байршуулсан.

**Шимт хөрс хуулалтанд ажиллах тоног төхөөрөмжүүд:** Шимт хөрсийг уурхайд ашиглагдаж байгаа хүнд машин механизм, бульдозероор хуулж, ачиж тээвэрлэх ажлыг дугуйт ачигч, гидроэкскаватор, технологийн автомашинуудаар гүйцэтгэв.

**Техникийн нөхөн сэргээлт болон нөхөн дүүргэлт хийгдэх механизмууд Зураг № 11**





**Шимт хөрс хуулалт хийж нөхөн сэргээлтийн талбайд буулгаж мөн нөөц овоолгод буулгав.**





**Зураг № 12** Төлөвлөгөөний дагуу овоолгын арын талбайгаас болон 1-р амны түрүүлэгч мөргөцөгөөс шимт хөрс хуулав.





**2022 оны Шимт хөрс хуулсан талбайн солбилцол**

| № | ӨРГӨРӨГ / X / | УРТРАГ / Y / | ӨНДӨРЖИЛТ |
|---|---|---|---|
| 1 | 5124228 | 310684.7 | 1215.315 |
| 2 | 5124269 | 310696.9 | 1215.874 |
| 3 | 5124256 | 311112.3 | 1219.43 |
| 4 | 5124074 | 311019.4 | 1219.661 |
| 5 | 5124228 | 310684.7 | 1215.315 |

**Шимт хөрсийг нөхөн сэргээлтийн талбайд буулгасан байдал.**





**Зураг № 13** Нөхөн хийх хэлбэржүүлсэн талбайд шимт хөрс буулгав.

**Зураг № 14** 2022 оны төлөвлөгөөний дагуу 4.5 га талбайн шимт хөрсний тэгшилгээ хийв.





**Техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийсэн талбайн солбилцол**

| № | ӨРГӨРӨГ / X / | УРТРАГ / Y / | ӨНДӨРЖИЛТ |
|---|---|---|---|
| 1 | 5122721.482 | 308750.31 | 1210.252 |
| 2 | 5122752.406 | 308786.784 | 1210.252 |
| 3 | 5122673.908 | 308810.571 | 1209.49 |
| 4 | 5122439.205 | 309046.86 | 1208.052 |
| 5 | 5122440.791 | 309031.794 | 1207.901 |
| 6 | 5122575.586 | 308815.329 | 1210.252 |
| 7 | 5122721.482 | 308750.31 | 1210.252 |
| 8 | 5122777.7 | 308948.538 | 1235.666 |
| 9 | 5122623.557 | 309063.987 | 1229.863 |
| 10 | 5122638.781 | 309279.659 | 1225.587 |
| 11 | 5122804.342 | 309053.837 | 1234.852 |
| 12 | 5122777.7 | 308948.538 | 1235.666 |

### 7.2.2. Биологийн нөхөн сэргээлт

Биологийн нөхөн сэргээлтийг гадаад овоолгын талбайд хэлбэржүүлэлт /техникийн нөхөн сэргээлт/ хийхээр төлөвлөсөн болно.

2021 оны 5-р сард төлөвлөгөөний дагуу 3.8 га талбайд Гэрээт ажилчидаар олон наст ургамалын үр болох Ерхөг, Согоовор, Өлөнгө гэх мэт үрээр үрсэлгээ хийлгэж Биологийн нөхөн сэргээлт хийсэн болно.

### 7.2.3. Нөхөн сэргээлтийн ажлын зардал

**Хүснэгт №5**

<table>
<tr><th>№</th><th>Зардлын утга</th><th>Хэмжих нэгж</th><th>Ажлын хэмжээ</th><th>Ашиглагдах техник, тайлбар</th><th>Нэгж ажлын зардал, мян.төг</th><th>Нийт зардал, мян.төг</th></tr>
<tr><td colspan="7">1. Техникийн нөхөн сэргээлтийн ажил</td></tr>
<tr><td>1</td><td>Шимт хөрсний үе давхаргыг хуулах, ачих</td><td>мян.$м^3$</td><td>46.1</td><td>Бульдозер, ачигч, автосамосвал</td><td colspan="2" rowspan="5">4 354 111.9</td></tr>
<tr><td>2</td><td>Ашиглагдсан орон зайг нөхөн дүүргэх</td><td>мян.$м^3$</td><td>2 045.8</td><td>Алхагч экскаватор</td></tr>
<tr><td>3</td><td>Овоолгын талбайг тэгшлэх, нягтаршуулах</td><td>га</td><td>4.5</td><td>Бульдозер</td></tr>
<tr><td>4</td><td>Талбайг шимт хөрсөөр хучих</td><td>мян.$м^3$</td><td>9.0</td><td>Экскаватор, автосамосваль, бульдозер</td></tr>
<tr><td>5</td><td>Тариалалтын өмнөх тэгшилгээний ажил</td><td>га</td><td>4.5</td><td>АвтоГрейдер</td></tr>
<tr><td colspan="2">Дүн</td><td colspan="2">сая.төг</td><td colspan="3">4 354 111.9</td></tr>
<tr><td colspan="7">2. Биологийн нөхөн сэргээлтийн ажлын зардал</td></tr>
</table>

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 6 | Биологийн нөхөн сэргээлт хийх зардал | га | 4.5 | Ерхөг, Өлөнгө, Царгасны үр авах. | | 5 600.0 |
| 7 | Уурхайн төв зам дагуу /зурвас маягаар/ мод тарих. | ширхэг | 3 600 | Хайлаас | 5800 | 20 880.0 |
| 8 | Уурхайд таригдсан мод, бут сөөг, зүлэг, нөхөн сэргээгдсэн талбайг услаж тордож арчлах | | | Гэрээт ажилтан авч ажиллуулах | 4x700.0x7 | 19 600.0 |
| **Нөхөн сэргээлтийн ажлын нийт зардлын дүн** | | **мян.төг** | | **46 080.0** | | |

**Нөхөн сэргээлтийн 4.5 га талбайд үрсэлгээ хийж байгаа байдал. Зураг № 15**



**Үрсэлгээ хийгдсэний дараах усалгаа. Зураг № 16**



**Нөхөн сэргээлтийн талбайн ургалтын явц.** **Зураг № 17**





Хаврын "Бүх нийтээрээ мод тарих үндэсний өдөр"-ийг тохиолдуулан Уурхайн ажилчидтай хамтран төв зам дагуу /зурвас маягаар/ 3600 ш хайлаас мод тарьсан.





**Зураг № 18** Уурхайн төв зам дагуу газрын хойд талын талбай





**Тарьсан моднуудын дараах усалгаа хийж байгаа явц.**




**Зураг № 19** Усалгаа хийж байгаа байдал.

**Уурхайн талбайд ургаж байгаа чацарганы 250 ш бут сийрүүлж шилжүүлэн суулгав.**

**Зураг №20**






**Зураг № 21** Уурхайн ЗХ-ийн талбай



**Зураг № 22** Уурхайн Төв конторийн урд талбай

**Зүлэгжүүлэлтийн дараах зэрлэг зулгааж байгаа байдал. Зураг № 23**





**Шивээговь сумын төвд тариалсан модыг 7 хоногт 1 удаа тогтмол услаж, шимт хөрс асгаж, уурхайд урд жилүүдэд таригдсан моднуудыг арчилж графикийн дагуу хийж гүйцэтгэсэн.**

**Зураг № 24**









### *7.3.* Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Уурхайн ашиглалтын явцад цаашид мэргэжлийн байгууллагаар дүйцүүлэн хамгааллын нарийвчилсан тооцоо, судалгаа хийлгэж экологийн хувьд ижил байх, нөлөөлөлд өртсөн газартай ойр байх, хугацааг нөлөөлөлтэй харьцангуйгаар тогтоох зарчмыг баримтлана.

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг БОНБҮ-ий тухай хуулийн 3.1.11, 9.6-д заасны дагуу авч хэрэгжүүлнэ.

### *7.4.* Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Шивээ-Овоо ХК нь өөрийн эдэлбэр газарт үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд сумын иргэд, оршин суугчид суурин, нүүлгэн шилжүүлэлт хийхгүй, нөхөн олговор олгохгүй.

### *7.5.* Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Уурхайн ашиглалтын орчинд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл болно. Монгол улсын "Соёлын өвийг хамгаалах тухай" хуулийн дагуу Шивээ Овоо ХК нь үйл ажиллагаа явуулж байх үед соёлын өв илэрсэн тохиолдолд Монгол улсын шинжлэх ухааны академийн Палеонтологийн төвд хандан хуулийн дагуу хамгаалах, малтлага хийлгэх ажил зохион байгуулахыг санал болгоно.

### 7.6. Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт Хүснэгт №17

| № | Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл | Урьдчилсан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Нэгжийн зардал, /мян.төг/ | Нийт зардал, /мян.төг/ | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Биелэлт /%/ |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Ажиллаж байх хугацаанд харшил үүсэх, байдлаас бэртэх зэргээр хүний эрүүл мэндэд нөлөөлөх. | Хөдөлмөр хамгааллын багаж хэрэгслээр хангах, Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулах, ажлын байранд яаралттай тусламжийн үед ашиглах эмийн сан бий болгох. | Уурхайд ажиллаж байгаа түр болон байнгын ажиллагсад | 56.9x542 | 30 840.0 | Уурхайн ажилчдын аюулгүй байдал, эрүүл мэндийг хамгаалах зүгээс өдөр бүрийн витамин болон бусад эмээр хангаж байх. | 100 |
| **2** | | Ажлын байрны аюулгүй ажиллагааны зааварчилгаар тогтмол өгөх, хөдөлмөр хамгааллыг сахих. | Уурхайн бүх ажилчид | - | - | Өдөр бүр ажилд гарахын өмнө бүх ажилчид холбогдох албан тушаалтнаас зааварчилгаа авах. | 100 |
| **3** | | Ажлын хувцасаар хангах. | Уурхайн бүх ажилчид | 496.6x542 | 269 915.7 | Өдөр бүр ажлын хувцасаа өмссөн байх. | 100 |
| Нийт | | | | | 300 755.7 | | 100 |

*Химийн бодис:* Шивээ Овоогийн уурхай нь химийн бодис ашигладаггүй бөгөөд нүүрсний шинжилгээний лабораторид 9 нэр төрлийн хуурай болон уусмал байдалтай бодис хадгалагдаж байна.

Нүүрсний шинжилгээний лаборатори нь нүүрсний чийглэг, үнслэг, илчлэг, дэгдэмхий, хүхэр зэрэг шинж чанарыг шинжлэх, бутлуурын өрөөнүүдэд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд химийн бодис, урвалжуудыг шкафанд төрөлжүүлэн хадгалж, шкафны хаалган дээр хаяг шошго, аюулын тэмдэглэгээ, шкафны тавиур бүрт хадгалагдаж байгаа бодисын нэр, химийн томъёо, хэмжээ, аюулын зэргийг тодорхой бичиж хадгалагдаж байна. Лабораторид байгаа химийн бодисыг жилд 1 удаа тоолон хадгалалтын хугацаа дууссан химийн бодисуудыг Аймгийн Мэргэжлийн Хяналтын албанд хүсэлт гарган, мэргэжлийн байгууллагаар устгуулдаг. 2021 онд хугацаа дуусах бодис байхгүй болно.

Уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны хэмжээнд ашиглагдаж байгаа химийн агууламж бүхий бодис, материал, хог хаягдлыг бүртгэлжүүлж мэдээллийн сан бүрдүүлэн ажиллаж байна. Химийн бодисын агууламж бүхий бодисын тээвэрлэлт, хадгалалт, ашиглалтанд холбогдох хууль болон дотоод журмын дагуу хяналт шалгалтыг тогтмол хийж байна.

Байгаль орчны мэргэжилтнүүд эрсдэл бүхий обьектуудыг холбогдох нэгжийн ажилтнуудтай хамтран шалгаж эрсдлийн үнэлгээг хийж гүйцэтгэж байна. 2018 оны 8-р сарын 22-ны өдрийн Захирлын зөвлөлийн хурлаар “Химийн бодис, тос тосолгооны материалын асгаралтын журам” А/81 тоот тушаалаар батлагдсан журмыг мөрдөж ажиллаж байгаа болно.

**Тэсрэх материалын агуулахын тухай товч тодорхойлолт**

2014 онд Шивээовоогийн хүрэн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх, нүүрсний уурхайд гүйцэтгэдэг тэсэлгээний ажлын зардлыг бууруулах зорилгоор өөрийн хэрэгцээнд зориулан “Энгийн найрлагат тэсрэх бодисын үйлдвэр” байгуулан ажиллаж байгаа болно. Тэсрэх бодисын үйлдвэрийн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний ажлыг “ЭКО СЕРВИС” ХХК гүйцэтгэсэн. Төслийн талбайн нь Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын нутагт,” Шивээ-Овоо” нүүрсний уурхайгаас 4 км зайд 4.2 га талбайг хамарсан байрлалтай.

Талбайг тойруулан хашаа татсан бөгөөд хашаан дотор байрлах хамгийн захын барилга нь хашаанаасаа 40 м зайтай байрлана гэж төлөвлөсөн. Хашааны гадна эргэн тойрон 50 м-ийн зай бүхий газарт хориотой бүс тогтоосон ба түүн дотор хашаанаас 5 м-ийн зайд 0.5 м гүн суваг тойруулан татсан. Үйлдвэрийн талбайг нийтэд нь хянах боломж бүхий өндөрт байрласан 2 ш харуулын байртай. Үйлдвэрийн барилга байгууламжуудын хооронд байх аюулгүйн зайг хүчин төгөлдөр мөрдөж буй норм, Монгол Улсын Тэсэлгээний ажлын нэгдсэн дүрэм-д заасан аргачлалаар тооцож тогтоосон. Энгийн найрлагат тэсрэх бодис харьцангуй хямд үнэтэй, бэлтгэхэд аюул осолгүй, тэсрэлтийн шинж чанарын үзүүлэлт өндөр зэрэг давуу талуудтай байдаг. Энгийн найрлагат тэсрэх бодис нь 94-97% мөхлөгт эсвэл хайрслаг аммиакийн шүүг 3-6 % дизелийн түлштэй хольж гаргаж авна.Төв агуулахад ажилладаг ажилтан ул өсгийдөө төмөр хадаасгүй гутал өмсөнө. Агуулахын багаж хэрэгслэл, хадаас түгжээ, хаалт бусад төмөр эдлэлийг оч үл үсэргэх материалаар бүрсэн байна. Хашааны орох гарах хаалгууд äýýð õàðóóëû í áàéð, ø àëãàí í ýâòð¿¿ëýõ öýãòýé. Àãóóëàõû í áàéð òóñ á¿ðò ãàë ýñýðã¿¿öýõ õýðýãñëýýð õàí ãàãäñàí áàéí à.¯ éëäâýð, àãóóëàõóóä í ü ãàí ö болон бүлэг аянга зайлуулагчаар хамгаалагдана.

**Химийн бодисын тооллогын хуудас** **Хүснэгт № 18**

| Аймаг, нийслэл | Говьсүмбэр | Улсын бүртгэлийн дугаар | 3212010001 |
|---|---|---|---|
| Сум, дүүрэг | Шивээговь | Регистрийн дугаар | 2004879 |
| Аж ахуйн нэгжийн нэр | “Шивээ-Овоо” ХК | Үйл ажиллагааны чиглэл | Нүүрс олборлох, борлуулах, боловсруулах |
| | | Зориулалтын агуулахтай эсэх | Агуулахын шаардлагагүй |

| Д/Д | Химийн бодисын нэр | Химийн бодисын томьёо | Ашиглагдаж байгаа эсэх | Хор, аюулын ангилал | Одоо байгаа кг |
|---|---|---|---|---|---|
| 1. | Вольфромын исэл | $WO_3$ | Ашиглаж байгаа | “бага зэрэг хортой” | 0.5 |
| 2. | Калийн иодид | KI | | “бага зэрэг хортой” | 0.7 |
| 3. | Калийн бромид | KBr | | “бага зэрэг хортой” | 0.7 |
| 4. | Мөсөн цууны хүчил | $CH_3COOH$ | | “Маш аюултай” | 0.02 |
| 5. | Силикогель | $SiO_2$ | | “Аюулгүй” | 4 |
| 6. | Бензойны хүчил | $C_7H_6O_2$ | | “хортой” | 1 |
| 7. | Этилийн спирт | $C_2H_5OH$ | | “бага хортой” | 0.4 |
| 8. | Тэсэлгээний эмульс | | | “хортой”, “тэсрэмтгий | 19 812.0 |
| 9. | Азотын бордоо | $NH_3NO_3$ | | “тэсрэмтгий” | 31 450.0 |

### 7.7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

"Шивээ-Овоо" ХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 7-р сарын тогтоолоор батлагдсан Байгаль орчны журмын 4.9-ийн 4.9.8 -д заасны дагуу компанийн тухай хуулийн 83-р зүйлийн 83.1, Хөдөлмөрийн дотоод журмын 3-р зүйлийн 3.1 дэх заалт, Захирлын зөвлөлийн 2018 оны 8-р сарын 22-ны өдрийн хурлын шийдвэрээр А/80-ийн 1-р хавсралт тушаалаар батлагдсан "Хог хаягдал цуглуулах, хадгалах, тээвэрлэх, устгах журам"-ын дагуу хэлтэс, хэсэг, алба, гэрээт ажилтнууд мөрдөн ажиллаж байгаа болно.

Уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулахтай холбогдон ажилчдын хоолны газар, контор, халуун усны газрууд, үйлдвэрийн цех хэсгүүдээс үйлдвэрлэлийн болон ахуйн хатуу, шингэн хог хаягдал гардаг. **Хог хаягдлын хүснэгт 19-д харуулав.**

Ахуйн хог хаягдлыг ачиж зайлуулах талаар **ландфилийн** аргаар устгасан. Аваарын эмнэлгээс гарах аюултай хог хаягдлыг Шивээговь сумын Нэгдсэн эмнэлгтэй хамтран гэрээ байгуулан / Аюултай хог хаягдлын журмын дагуу / ажиллаж байна.

Уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны хэмжээнд ашиглагдаж байгаа химийн агууламж бүхий бодис, материал, хог хаягдлыг бүртгэлжүүлж мэдээллийн сан бүрдүүлэн ажиллаж байна. Химийн бодисын агууламж бүхий бодисын тээвэрлэлт, хадгалалт, ашиглалтанд холбогдох хууль болон дотоод журмын дагуу хяналт шалгалтыг тогтмол хийж байна.

Мөн 2022 онд Аюултай бодисын худалдан авалт, хадгалалт, хэрэглээний журам боловсруулан батлуулж, асгаралтын иж бүрдлийг худалдан авч уурхайн шаардлагатай газруудад байрлуулж ажилласан.

Шатхуун түгээгүүрт хадгалагдаж байгаа Ажилласан масло, тосыг "МОНПИТИ ОЙЛ" ХХК-тай гэрээ байгуулан өгсөн болно.

Уурхайн талбайд Хог хаягдлын 2 цэг байрлуулан тодорхой хэмжээний ангилан ялгалт хийж байна.

**Хаялага нуурын орчмын хогийг болон цоорхой рашааны орчмын хогийг Уурхайн ажилчид болон гэрээт ажилчидтай хамтран их цэвэрлэгээ хийсэн.**




**Зураг № 25** 2022 оны 5-р сарын 24, 26-н ба 7-р сарын 5-нд уурхайн ажилчидтай хамтран хогны цэвэрлэгээ хийв



**Зураг № 26** Хаялага нуурын болон цоорхой рашааны хогийн цэгийн хогийг ачиж байгаа байдал




**Зураг № 27** Хаялага нуурын болон цоорхой рашааны хогийн цэгийг цэвэрлэсэн байгаа байдал









**АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ АГУУЛАХ ЦЭГ**

**ЗУРАГ № 35**






## ХОГ ХАЯГДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Д/Д | Ажлын төлөвлөгөө | Төсөв мян.төг | Ажлын биелэлт | Тайлбар |
|---|---|---|---|---|
| **Ахуйн болон үйлдвэрийн хог хаягдал** | | | | |
| 1 | Хаялага нуурын хог цэвэрлэх. | ҮА-ын зардалд | 100 % | Төлөвлөгөөний дагуу хаялага нуур орчмын хог цэвэрлэгээг энэ жил 2 удаа зохион байгуулан хийсэн. |
| 2 | Ахуйн хатуу хог хаягдлыг Ландфилийн хүнхээлд тээвэрлэн хүргэж, устгах. | ҮА-ын зардалд | 100 % | Уурхайн ахуйн хог хаягдлыг график гарган устгасан. |
| **Аюултай хог хаягдал** | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 3 | Хог хаягдлын цэг, бохирын цооногт тогтмол ариутгал хийх. | 2 000.0 | 100% | Хог хаягдлын цэг, бохирын цооногт тогтмол ариутгал хийх ажлыг ХАБЭАХэлтэстэй хамтран график гарган гүйцэтгэсэн. |
| 4 | Аюултай хог хаягдлыг ангилан хадгалах, тохирох аргын дагуу зайлуулах, устгах. | - | 100% | Аюултай хог хаягдал болох масло, тосны шүүр, агаар шүүгч болон галын хор зэргийг консервацид ангилан хадгалж байгаа. Ажилласан маслыг тусгай зөвшөөрөлтэй “МОНПИТИ ОЙЛ” ХХК-тай гэрээ байгуулан устгуулсан. |
| 5 | Ааарын эмнэлэгээс гарах аюултай хог хаягдлыг устгах. | - | 100% | Шивээговь сумын Нэгдсэн эмнэлэгтэй хамтран гэрээ байгуулан / Аюултай хог хаягдлын журмын дагуу / ажиллаж байна. |
| 6 | Нийт хувь /%/ | 2 000.0 | 100.0% | |

**Хог хаягдлын бүртгэл** **Хүснэгт № 19**

| | Хог хаягдлын нэр | Код | Аюулын зэрэглэл | Жилд гарах нийт хэмжээ Шингэн-/м$^3$/жил/ Хатуу - /тн/жил/ | Дахин ашиглагдах | Устгах | Хадгалах | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Ахуйн | Цаас | Т 01 01 | | 1-1.5 тн | үгүй | Булшлах | Тээвэрлэж хаях | Ландфилийн аргаар булна. |
| | Гуанзны хог | Т 01 03 | | 18 тн | үгүй | Булшлах | Тээвэрлэж хаях | Ландфилийн аргаар булна. |
| | Хуванцар | Т 01 27 | | 1.6 тн | тийм | Хадгална | 2-догч түүхий эд | |
| | Шавар шороо | Т 02 02 | | 2.5 тн | үгүй | Булшлах | Тээвэрлэж хаях | Ландфилийн аргаар булна. |
| Үйлдвэрийн | Хөнгөнцагаан | И 03 03 | | 150 м | тийм | Хадгална | 2-догч түүхий эд | |
| | Кабель | Ө 02 06 | | 18 м | тийм | Хадгална | 2-догч түүхий эд | |
| | Хаягдал төмөр | И 02 99 | | 25 тн | тийм | Хадгална | 2-догч түүхий эд | |
| | Хаягдал тросс | И 02 99 | | 4971 м | тийм | Хадгална | 2-догч түүхий эд | |
| | Нүүрсний /үнсний/ хог | Т 03 99 | | 520 тн | үгүй | булшлах | Тээвэрлэж хаях | Ландфилийн аргаар булна. |
| Аюултай, хортой | Ажилласан тос масло | 13 02 04 | А | 18 000 л | тийм | Хадгална | 2-догч түүхий эд | |
| | Трансформаторын масло | 13 03 06 | А | 600 л | тийм | Хадгална | 2-догч түүхий эд | |
| | Аккумлятор | 16 06 01 | А | 22 ш | тийм | Хадгална | 2-догч түүхий эд | |
| | Тосны шүүр | 16 01 04 | А | 507 ш | тийм | Хадгална | 2-догч түүхий эд | Нийлүүлэгч ААН-д өгнө. |
| | Агаар шүүгч | 16 01 18 | Х | 430 ш | тийм | Хадгална | 2-догч түүхий эд | Нийлүүлэгч ААН-д өгнө. |
| | Арчих материал | 15 02 01 | Х | 14.0 тн | үгүй | Булшлах | Тээвэрлэж хаях | Ландфилийн аргаар булна. |
| | Тоормозны накладка | 16 01 08 | Х | 102 хос | үгүй | Булшлах | 2-догч түүхий эд | Ландфилийн аргаар булна. |
| | Дугуй | - | - | 104 ш | тийм | Хадгална | 2-догч түүхий эд | |
| | Галын хор | - | - | 96 ш | тийм | Хадгална | 2-догч түүхий эд | |

### *7.8.* Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

"Шивээ-Овоо" ХК-ийн ТУЗ-ийн 2017 оны 7-р сарын тогтоолоор батлагдсан Байгаль орчны журмын 4.9-ийн 4.9.1, 4.9.2, 4.9.5, 4.9.6 -д заасны дагуу компанийн тухай хуулийн 83-р зүйлийн 83.1, Хөдөлмөрийн дотоод журмын 3-р зүйлийн 3.1 дэх заалт, Захирлын зөвлөлийн 2018 оны 8-р сарын 22-ны өдрийн хурлын шийдвэрээр А/83-ийн 1,2,4-р хавсралт тушаалаар батлагдсан зааврын дагуу хийгдсэн.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд төлөвлөгдсөн агаар, хөрс, усан орчны бохирдолын хими, хүнд металлын шинжилгээнүүдийг Говьсүмбэр аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний лабораториор хийлгэсэн.

Шинжилгээний хариуг хүлээн авч Говьсүмбэр аймгийн Мэргэжлийн Хяналтын Газарт хүргүүлэн улсын байцаагчийн дүгнэлт гаргуулсан. Шинжилгээний дүнгийн дүгнэлтийг тайланд хавсаргав.

**Ус, агаар, хөрсний шинжилгээний дээж авсан газрын солилцол Хүснэгт № 20**

| Цэгийн дугаар | Нэр | Солбицол | | |
|---|---|---|---|---|
| | | Уртраг | Өргөрөг | Өндөржилт |
| 1 | Таригдсан модны талбай | 5122392.471 | 308518.920 | 1203.30 |
| 2 | Уурхайн уурын зуух | 5122383.546 | 308586.695 | 1203.95 |
| 3 | 21-р худаг | 5122374.250 | 308694.731 | 1204.97 |
| 4 | Цайны газар | 5122248.707 | 308619.985 | 1202.94 |
| 5 | АБХ-ийн зүүн тал | 5122198.062 | 308560.864 | 1201.40 |
| 6 | Засварын хэсэг | 5122259.358 | 308493.629 | 1202.60 |
| 7 | Консерваци | 5122188.443 | 308043.952 | 1200.32 |
| 8 | ШТС | 5121039.750 | 308429.124 | 1192.21 |
| 9 | ТДХ-ийн цайны газар | 5120850.018 | 308526.046 | 1193.54 |
| 10 | Лаборатори | 5120714.105 | 308642.257 | 1195.02 |
| 11 | Вагон ачилтын хэсэг | 5120660.138 | 308651.376 | 1195.38 |
| 12 | Агуулахын талбай | 5120729.161 | 308923.913 | 1197.04 |
| 13 | Ус шүүрүүлэх шугамын хоолой | 5120469.148 | 309376.768 | 1199.75 |
| 14 | Ус шүүрүүлэхийн хэсэг | 5121765.907 | 310937.337 | 1220.06 |
| 15 | Нөхөн сэргээлтийн талбай | 5122444.109 | 310042.586 | 1219.00 |
| 16 | Гадаад овоолго | 5122734.593 | 308920.597 | 1212.33 |
| 17 | Хогийн цэг | 5123357.292 | 309101.866 | 1196.47 |
| 18 | Нүүрс гаргалт | 5123965.199 | 310712.107 | 1174.84 |
| 19 | Нүүрс ачилт | 5123897.809 | 310737.169 | 1168.02 |
| 20 | Хөрс хуулалт | 5123780.885 | 311114.776 | 1197.36 |
| 21 | 11/70 алхагч экскоdouble | 5123560.301 | 310982.258 | 1162.81 |
| 22 | 25/90 алхагч эксковатор | 5122894.905 | 311079.324 | 1157.99 |
| 23 | Тэсрэх материалын агуулах | 5126072.824 | 308753.619 | 1213.12 |
| 24 | ЭКГ-10и эксковатор | 5123788.538 | 310929.863 | 1182.92 |

**Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал  Хүснэгт № 21**

| Хяналт-шинжилгээний үзүүлэлт | Цэгийн тоо | Хяналтын цэгийн байршил | Давтамж | Төсөв. мян төг | Зөвшөөрөгдөх хэмжээ | |
|---|---|---|---|---|---|---|
| **Агаар** | 15 цэг | 1. Ажлын байрууудад 10 цэг<br>2. Нүүрс гаргалтын орчин<br>3. Нүүрс ачилтын орчин<br>4. Хөрс хуулалтын орчин<br>5. Ачилтын өрөө<br>6. Шатахуун түгээгүүрийн орчин | 5, 9-р сард | 22x36.0 =792.0 | $SO_2$-10мг/м$^3$<br>$NO_2$-5мг/м$^3$<br>CO-20мг/м$^3$<br>$CO_2$-9000мг/м$^3$<br>Тоос-10мг/м$^3$ | |
| **Гадаргын ус** | 1 цэг | Хаялага нуур | 5, 9-р сард | 50.0 | CI | 300.0 |
| | | | | | $SO_4$ | 100.0 |
| | | | | | $NO_2$ | 0.02 |
| | | | | | $NO_3$ | 9.0 |
| | | | | | Ca | 59.9 |
| | | | | | Mg | 144.8 |
| | | | | | $NH_4$ | 0.5 |
| | | | | | Fe+2 | 1.0 |
| **Газрын доорхи ус** | 6 цэг | 1. 21-р худаг<br>2. Уулын ажилчдын цайны газрын ус<br>3. Ус шүүргүүлэлтийн нуур луу ус зутгах труба<br>4. Орон сууцны ус<br>5. Лабораторийн крантны ус<br>6. Цайны газрын зөөврийн ус | 5, 9-р сард | 5x50.0 =250.0 | Zn | 1.0 |
| | | | | | Mn | 0.5 |
| | | | | | Pb | 0.1 |
| | | | | | Cd | 0.03 |
| | | | | | Cu | 0.3 |
| | | | | | Cr | 0.3 |
| **Хөрс** | 9 цэг | 1. Мод таригдсан талбай<br>2. Хог хаягдлын цэг<br>3. Авто засварын баруун тал<br>4. Нөхөн сэргээлтийн талбай<br>5. Уулын уурын зуухны орчин<br>6. ШТС-ын хадгалах савны дэргэд<br>7. Гадаад овоолго<br>8. Авто засварын урд тосолгооны хэсгээс<br>9. Тэсрэх материалын агуулах | 5, 9-р сард | 9x36.0 =324.0 | Cu -100.0 мг/кг<br>Pb -100.0 мг/кг<br>Cd- 3.0 мг/кг<br>As -150.0 мг/кг<br>Zn -300.0 мг/кг | |
| **Ургамал** | 2 цэг | Үйлдвэрлэлийн бүсийн ашиглалтанд º ðòº ã¿é õýñýãò<br>Биологийн нөхөн сэргээлт хийгдсэн, óðãàì àëæóóëñàí òàëáàé | Жилд 1 удаа | Үйл ажиллагааны зардалд | | |
| **Амьтан** | 1 цэг | Хаялгын нуурын усны загас, шувуудыг судлах судлагааны ажлыг мэргэжлийн байгуулагаар хийлгэх | Жилд 1 удаа | | - | |
| | | **Хяналт шинжилгээний хөтөлбөрийн төсөв /мян.төг/** | | **2x1470.5=2941.0** | | |

### 7.9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

- Байгаль орчныг хамгаалах төлөвлөөгөөг боловсруулан хэрэгжүүлэн ажилласан.
- Үйлдвэрлэлийн технологийн горим, заавар, аюулгүй ажиллагааны шаардлага, дүрэм, журам стандартыг ажилчдад эзэмшүүлэх, байгаль орчныг хамгаалах талаархи сургалтын ажлыг Хүний нөөцийн алба болон ХАБЭА хэлтэс төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн.
- Байгаль орчинд үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зөвлөмж, байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг мөрдлөг болгон ажилласан.
- Гэрээт ажилчид ХАБЭА- н сургалтанд хамрагдав.
- “Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлт”-ийн анхдугаар зөвлөгөөн чуулга уулзалтад оролцов.
- Шивээговь сумын нутаг орших “Хаялага нуур”-ын шүүрүүлэхийн усны эхийг хамгаалж хашаажуулж засаж янзлав.
- Шивээговь сумын төв замуудын эвдэрсэн газруудад шороо асгаж автогрейдерээр тэгшилж янзлав.




**Зураг № 36** 2022 оны 3-р сараас 8-р сар хүртэл Уурхайн бүх ажилчидад байгаль орчныг хамгаалах талаархи болон ХАБЭА- н сургалтанд график гаргаж хамрагдуулав.




**2022 оны 3-р сарын 11-нд “Ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлт”-ийн анхдугаар зөвлөгөөн чуулга уулзалтад оролцов.** **Зураг №37**






**Шивээговь сумын төв замын хур бороонд эвдэгдсэн замыг шороо асгаж хэлбэршүүлэв**

**Зураг № 40**









**Шивээговь сумын төвийн туурь хог цэвэрлэгээ хийж байгаа байдал**













## 7.10. БОМ-ийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оршин суугч, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөөний биелэлт

**Хүснэгт № 22**

| БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх оршин суугчид, оролцогч талууд Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр | Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр | Мэдээний агуулга | Хугацааны тов | Хэлэлцүүлгээр санал авах чиглэл | Зохион байгуулах газар | Биелэлт хувиар /%/ Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|
| Аймгийн БОАЖГ болон Сумын ЗДТГазарт тайлагнах | Тайланг албан бичгээр хүргүүлэх | 2021 он Бүтэн жилийн тайлан | 11-р сар | Албан тоот | ХНА, ТехБХ, БОМ | 100% |
| Аймгийн БОАЖГ болон Сумын ЗДТГазарт тайлагнах | Төлөвлөгөөг албан бичгээр хүргүүлэх | 2022 оны Бүтэн жилийн төлөвлөгөө | 12-р сар | Албан тоот | ХНА, ТехБХ, БОМ | 100% |
| Сумын оршин суугчдад тайлагнах | “Нээлттэй өдөрлөг” | Компани танилцуулах | 12-р сар | Санал хүсэлт | ХНА, БОМ | КОВИД-19 цар тахлын улмаас хойшлогдсон болно. |

**Байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөөний нэгдсэн биелэлт Хүснэгт №23**

| № | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ | Хамрах хүрээ | Хэм/нэгж | Тоо/хэм | Нэгжийн зардал мян.төг | Нийт зардал мян.төг | Хэрэгжүүлэгч | Биелэлт |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Зам талбай услах | Карьерын зам | тн | 1475 | 16 471.65 | **24 295.68** | УНХ, АБХ, Авто-замын инженер | 40 тонны TEREX маркийн 2 машинаар 1475 рейсс хийж 59000 тн усаар зам талбайг усалсан Биологийн нөхөн сэргээлтийн талбайг усалсан. |
| 2 | Шимт хөрс хуулалт | УНХ | Мян.$м^3$ | 46.1 | 2.2 | **91 520.0** | ТехБХ Байгаль орчны мэргэжилтэн | 46.1 мян $м^3$ шимт хөрс хуулсан. |
| 3 | Шимт хөрсөөр хучих | УНХ | га | 4.5 | 0.810 | **3 645.0** | УНХ, АБХ | 9.0 мян $м^3$ шимт хөрс хуулж, 4.5 га биологийн нөхөн сэргээлт хийх талбайд шимт хөрс буулгах ажил хийсэн. |
| 4 | Нөхөн дүүргэлт | УНХ | Мян.$м^3$ | 4 290.6 | 0.851 | **3 651 300.6** | УНХ | ЭШ 25/90 алхагч экскаватор ЭШ 11/70 алхагч экскаватор хайгуулын IX-XIII шугамын хооронд 2045.8 мян.$м^3$ хөрс хуулж, 2244.8 мян.$м^3$ дахин шидэлтийн ажлыг хийсэн./11-р сарын 01-ийн байдлаар/ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | Биологийн нөхөн сэргээлт | УНХ | га | 4.5 | | **5 600.0** | ТехБХ, Байгаль орчны мэргэжилтэн | Биологийн нөхөн сэргээлт хийх 4.5 га талбайд Гэрээт ажилчдаар үрсэлгээ хийлгэсэн. |
| 6 | Шивээ-говь сумын төвд болон Уурхайн ажлын байрны гадна талбайд мод тарих | Бүх хэлтэс, хэсэг, алба | ширхэг | 3 600 | 5.8 | **20 880.0** | ТехБХ, Байгаль орчны мэргэжилтэн | 2022 оны 5-р сарын 14-нд “Мод тарих” өдрөөр 3 600 ш Хайлаас тарьсан. |
| 7 | Гэрээт ажилтан авах | ТехБХ | | 4 | 700,0х4х7 | **19 600.0** | ТехБХ, Байгаль орчны мэргэжилтэн | 4 гэрээт ажилтанг 4, 5, 6, 7, 8, 9,10 -р сард мод усалгааны болон биологийн нөхөн сэргээлт хийх ажилд авч ажиллуулсан. |
| 8 | Орчны болон ажлын байрны цэвэрлэгээ, хогийн цэг байгуулах | Хэсэг нэгжүүд | сар | 5-р, 10-р | - | **УА-ын зардалд** | ХАБЭА, Байгаль орчны мэргэжилтэн | Уурхайн орчны болон ажлын байрны цэвэрлэгээ, их цэвэрлэгээг хэсэг цехүүдэд 7 хоног, сар бүрт тогтмол хийсэн. Мөн уурхайн талбайд “Хогийн цэг” байгуулан графикийн дагуу ачиж зайлуулан ажиллаж байна. |
| 9 | Шивээговь сумын ЗДТГазарт болон Говь-сүмбэр аймгийн БОАЖГ тайлагнах | Орон нутагт | жил | 1 | - | - | Байгаль орчны мэргэжилтэн | Говь-сүмбэр аймгийн БОАЖГ, МХГ болон Шивээговь сумын ЗДТГазарт 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хагас жилийн тайлангийн нэг хувийг өгч хүргүүлсэн. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 10 | Агаар дахь бохирдлын шинжилгээ | Ашиглалтын талбай | 5, 9-р сард | 22 | 36.0x22 | **2 832.0** | Итгэмжлэгдсэн лаборатори | Говьсүмбэр аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв лабораториар агаарын бохирдолын шинжилгээг хийлгэсэн. Шинжилгээний хариуг хавсаргав. |
| 11 | Гүний усны шинжилгээ | Ашиглалтын талбай | 5, 9-р сард | 5 | 250.0 | | Итгэмжлэгдсэн лаборатори | Говьсүмбэр аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв лабораториар усны химийн шинжилгээг, хүнд металлын шинжилгээг хийлгэсэн. Шинжилгээний хариуг хавсаргав. |
| 12 | Гадаргын усны шинжилгээ | Ашиглалтын талбай | 5, 9-р сард | 1 | 50.0 | | | |
| 13 | Хөрсний шинжилгээ | Ашиглалтын талбай | 5, 9-р сард | 9 | 9x36.0=324.0 | | Итгэмжлэгдсэн лаборатори | Говьсүмбэр аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв лабораториар хөрсний хүнд металь, химийн шинжилгээг тус тус хийлгэсэн. Шинжилгээний хариуг тайланд хавсаргав. |
| 14 | Бохир ус | Ашиглалтын талбай | 5, 9-р сард | 1 | 54.5 | **109.0** | Итгэмжлэгдсэн лаборатори | Говьсүмбэр аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төв лабораториар усны микробиологийн шинжилгээг хийлгэсэн. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 15 | Сургалт, семинар зохион байгуулах | Уурхай | 3-8-р сард | - | - | - | ХНА, Байгаль орчны мэргэжилтэн | 2022 оны 3-8р сард БОМТ-ий дагуу 4 гэрээт ажилтануудыг болон Уурхайн бүх ажилчидыг Байгаль орчин, ХАБЭА-н сургалтанд хамрагдсан болно. |
| | **Үйл ажиллагааны зардал<br>БОМТ-ний зардал<br>Нийт зардал / мян төг/** | | | | **3 819 781.68<br>49 021.0<br>3 770760.68** | | | |